



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 29 (506)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Хувиргасан амьд организмын тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Монгол Улсын 2006 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны наймдугаар сарын 7

№29 (506)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

328.	Хувиргасан амьд организмын тухай	694
329.	Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай	699
330.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	699
331.	Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай	699
332.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	700

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

333.	Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 46	700
334.	Монгол Улсын 2006 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай	Дугаар 49	702
335.	Монгол Улсын Их Хурлын даргын алба хашиж байсан Ц.Нямдоржийн хамгаалалт, хангамжийн тухай	Дугаар 50	703

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

336.	Ринченгийн Нямаад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай	Дугаар 144	703
337.	Чоймболын Долгорт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай	Дугаар 145	703
338.	Дангаасүрэнгийн Салданд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 146	703
339.	Цэрэндоржийн Дашдоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 147	704
340.	Дансранжавын Лхагвад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 148	704
341.	Жигжидийн Болдбаатарт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 149	704
342.	Цэндсүрэнгийн Баярбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 150	704
343.	Лүүрэвийн Лхагвасүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 151	705
344.	Даваагийн Цэгээнжавт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 152	705
345.	Бадарчийн Отгонбаярт Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 153	705
346.	Цогбадрахын Пүрэвхүүд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 154	705

347.	Дамбадаржаагийн Ононд Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай	Дугаар 155	706
348.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 156	706
349.	Цэдэндоогийн Буянбатад Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай	Дугаар 157	712
350.	Өлзийгийн Хашхүүд Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай	Дугаар 158	712
351.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 159	713
352.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 160	714
353.	Даян аварга цол олгох тухай	Дугаар 166	714
354.	Манлай уяач цол олгох тухай	Дугаар 167	714
355.	Алдарт уяач цол олгох тухай	Дугаар 168	714
356.	Үндэсний сурын харваачдад цол олгох тухай	Дугаар 170	715
357.	Улсын начин цол олгох тухай	Дугаар 171	715
358.	Улсын харцага цол олгох тухай	Дугаар 172	715
359.	Улсын заан цол олгох тухай	Дугаар 173	716
360.	Улсын гарьд цол олгох тухай	Дугаар 174	716
361.	Улсын арслан цол олгох тухай	Дугаар 175	716
362.	Зарлигт нэмэлт өөрчлөлт оруулах тухай	Дугаар 179	716

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хувиргасан амьд организмыг гарган авах, ашиглах, улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэрт биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хувиргасан амьд организмын тухай хууль тогтоомж

2.1. Хувиргасан амьд организмын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль², Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль³, Технологи дамжуулах тухай хууль⁴, энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹ Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Үндэсний аюулгүй байдлын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

³ Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Технологи дамжуулах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

2.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "биоаюулгүй байдлыг хангах" гэж хувиргасан амьд организмээс хүний эрүүл мэнд, амьтан, ургамал болон биологийн бусад төрөл зүйлд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, аюулгүй болгох цогц арга хэмжээг;

3.1.2. "хувиргасан амьд организм" гэж орчин үеийн биотехнологийн аргаар гарган авсан удамшлын мэдээллийн шинэ хослол бүхий аливаа амьд организмыг;

3.1.3. "биотехнологи" гэж лабораторийн нөхцөлд нэг биетийн эсэд өөр биетийн тодорхой ашигт чанарыг агуулагч ДНХ /дезоксирибонуклеинийн хүчил/ -г холбох, эсхүл ангилал зүйн хувьд ялгаатай организмын эсүүдийг шууд холбох аргаар судалгаа, үйлдвэрлэлийн зориулалттай эрлийз биет гарган авах арга технологийг;

3.1.4. "хувиргасан амьд организмыг ашиглах" гэж эрдэм шинжилгээ, туршилт, үйлдвэрлэлийн аргаар гарган авсан хувиргасан амьд организмыг өмчлөх, эзэмших, ашиглахад чиглэгдсэн үйл ажиллагааг;

3.1.5. "битүү системд ашиглах" гэж хувиргасан амьд организмыг байгаль орчинд тархах, эсхүл хүний эрүүл мэндэд нөлөөлөхөөс бүрэн сэргийлсэн тусгай орчин буюу зориулалтын лаборатори, хүлэмжид явуулах аливаа үйл ажиллагааг;

3.1.6. "эрсдэл" гэж хувиргасан амьд организм нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө учруулж болзошгүй үр дагавар үүсэх магадлалыг;

3.1.7. "эрсдлийн үнэлгээ" гэж хувиргасан амьд организм нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй болохыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг.

4 дүгээр зүйл. Биоаюулгүй байдлыг хангах үндэсний хороо

4.1. Монгол Улсад биоаюулгүй байдлыг хангах ажлыг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Биоаюулгүй байдлыг хангах орон тооны бус Үндэсний хороо /цаашид "Үндэсний хороо гэх"/ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

4.2. Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа үндэсний аюулгүй байдлыг хангах, хэрэглэчийн эрхийг хамгаалах, нээлттэй байх зарчмыг удирдлага болгоно.

4.3. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд байгаль орчин, үйлдвэр, худалдаа, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, улсын мэргэжлийн хяналтын байгууллага, биотехнологийн чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндэсний хорооны дүрмийг баталж, бүрэлдэхүүнийг нь томилж, чөлөөлнө.

4.5. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд ажлын албатай байна.

4.6. Үндэсний хороо нь дэргэдээ хувиргасан амьд организмын эрсдлийн үнэлгээний тайланд мэргэжлийн дүгнэлт өгөх чиг үүрэг бүхий шинжлэх ухааны орон тооны бус зөвлөл байгуулан ажиллуулж болно.

4.7. Үндэсний хороо нь хуралдааныхаа дэг, энэ хуулийн 4.6-д заасан зөвлөлийн ажиллах журмыг батална.

4.8. Үндэсний хорооны зохицуулагч бөгөөд нарийн бичгийн дарга нь орон тооны байх бөгөөд Үндэсний хорооны зохицуулагч нь Картагений Протоколын нарийн бичгийн дарга нарын газартай харилцана.

5 дугаар зүйл. Үндэсний хорооны бүрэн эрх

5.1. Үндэсний хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. биоаюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг боловсруулж, Засгийн газраар батлуулан хэрэгжүүлэх, биотехнологийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.1.2. биоаюулгүй байдлыг хангах журам, төлөвлөгөө боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулах;

5.1.3. хувиргасан амьд организмыг улсын хил нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход дүгнэлт гаргах;

5.1.4. хувиргасан амьд организмыг гарган авахаар боловсруулсан төслийг хянан хэлэлцэх, гарган авсан хувиргасан амьд организмыг ашиглах эсэх талаар дүгнэлт гаргах;

5.1.5. биоаюулгүй байдлыг хангах байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах;

5.1.6. хувиргасан амьд организмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу устгах ажлыг зохион байгуулах;

5.1.7. энэ хуулийн 5.1.3, 5.1.4-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт мэдээлэл, баримт бичгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулан авах.

5.2. Үндэсний хорооны аливаа шийдвэр нээлттэй байх бөгөөд гаргасан шийдвэрээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэх, гарган авах, эрсдлийн үнэлгээ хийх

6 дугаар зүйл. Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэх

6.1. Хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх зөвшөөрлийг Үндэсний хорооны дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгох бөгөөд уг зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.2. Зөвшөөрлийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл авах хүсэлтээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана.

6.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрөл авах хүсэлтдээ дараахь баримт бичгийг хавсаргана:

6.4.1. импортлогч талын мэдэгдэл буюу хувиргасан амьд организмд импортлогч болон экспортлогч орны Засгийн газраас эрх олгогдсон итгэмжлэгдсэн эрдэм шинжилгээний байгууллагаар эрсдлийн үнэлгээ хийлгэсэн тухай дүгнэлт;

6.4.2. хувиргасан амьд организмын онцлог шинжийн талаархи танилцуулга, үржиж чадахуйц нөхцөлийн тодорхойлолт;

6.4.3. хувиргасан амьд организмд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн ажлын тайлан;

6.4.4. хувиргасан амьд организмтай харьцах үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, заавар;

6.4.5. иргэн бол иргэний үнэмлэхийн, аж ахуйн нэгж, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

6.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг хүсэлт, түүнд хавсаргасан баримтаар Үндэсний хорооны дүгнэлт гаргуулж, түүнийг үндэслэн зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргана.

6.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараахь үндэслэлээр зөвшөөрлийг хүчингүй болгоно:

6.6.1. энэ хуулийн 6.4-д заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн;

6.6.2. зөвшөөрлийн үндсэн дээр хилээр нэвтрүүлж буй хувиргасан амьд организм аюултай нь тогтоогдсон.

6.7. Хувиргасан амьд организмтай харьцах үеийн аюулгүй ажиллагааны дүрэм, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, зааврыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих нийтлэг шаардлага, улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэхийг хориглох, түр саатуулах, устгах

7.1. Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих нийтлэг шаардлага, улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэхийг хориглох, түр саатуулах, устгах үйл ажиллагаанд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөнө.

7.2. Эрсдлийн үнэлгээгээр хор аюултай нь тогтоогдсон хувиргасан амьд организмыг устгах, хоргүйжүүлэх ажиллагааг улсын байцаагчийн хяналтын дор гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл. Хувиргасан амьд организмыг нэвтрүүлэх боомт

8.1. Хувиргасан амьд организмыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх боомтыг Үндэсний хорооны саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

9 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмыг гарган авах, үйлдвэрлэх

9.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хувиргасан амьд организмыг гарган авах, үйлдвэрлэх төслөө Үндэсний хороонд урьдчилан ирүүлж хэлэлцүүлнэ.

9.2. Үндэсний хороо төслийг хүлээн авч хэлэлцээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

9.2.1. төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын болон эрсдлийн үнэлгээ хийлгүүлэх шийдвэр гаргах;

9.2.2. тухайн төслийг хэрэгжүүлэхээс татгалзах.

9.3. Энэ хуулийн 9.2.1-д заасан шийдвэр гарсан бол иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний



тухай хуулийн⁴ 4.1-д заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу эрсдлийн үнэлгээ хийлгэн холбогдох тайланг Үндэсний хороонд ирүүлнэ.

9.4. Үндэсний хороо энэ хуулийн 9.3-т заасан тайланг хэлэлцэн хувиргасан амьд организмыг ашиглах, үйлдвэрлэх эсэх талаар дүгнэлт гаргана.

9.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хувиргасан амьд организмыг гарган авах төслийг зөвхөн битүү систем ашиглан хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Хувиргасан амьд организмд эрсдлийн үнэлгээ хийх

10.1. Хувиргасан амьд организмд эрсдлийн үнэлгээг зөвхөн итгэмжлэгдсэн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.

10.2. Итгэмжлэгдсэн эрдэм шинжилгээний байгууллагад эрсдлийн үнэлгээ хийх эрхийг Үндэсний хорооны саналыг үндэслэн Засгийн газар олгоно.

10.3. Эрсдлийн үнэлгээг Картагений Протоколын 3 дугаар хавсралтын дагуу хийж гүйцэтгэнэ.

11 дүгээр зүйл. Технологийн нууцлал хадгалах

11.1. Үндэсний хорооны гишүүн, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох ажилтан, энэ хуулийн 4.6-д заасан зөвлөлийн гишүүн нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олж мэдсэн хувиргасан амьд организмын технологийн нууцлалыг хадгалах үүрэгтэй.

11.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хувиргасан амьд организмын технологийг нууцлах талаархи үндэслэлээ Үндэсний хорооны ажлын албанд ирүүлнэ.

11.3. Ажлын алба нь технологийн нууцлалын үндэслэл, мэдэгдлийг судалж, нууцлах эсэх талаархи холбогдох баримт бичгийг төрийн нууцын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

11.4. Үндэсний хорооны ажлын албанд технологийн нууцлал хариуцсан ажилтанг тусгайлан томилоно.

11.5. Технологийн нууцлалыг хангахдаа Төрийн нууцын тухай⁵ хуулийг баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Биоаюулгүй байдлыг хангах

12 дугаар зүйл. Биоаюулгүй байдлыг хангах

12.1. Хувиргасан амьд организмын тухай хуулийг хэрэгжүүлэх нийтлэг журмыг Засгийн газар батална.

12.2. Энэ хуулийн 12.1-д заасан журамд биоаюулгүй байдлыг хангах талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээг тусгана.

13 дугаар зүйл. Хувиргасан амьд организмыг ашиглах

13.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зохих журмын дагуу дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авсан нөхцөлд хувиргасан амьд организмыг гарган авах, туршилт явуулах, ашиглах, үйлдвэрлэх эрх эдэлнэ.

13.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хувиргасан амьд организмыг ашиглахдаа хувиргасан амьд организмын аюулгүй байдлыг хангах журмыг дагаж мөрдөнө.

13.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гарган авсан, үйлдвэрлэсэн болон ашиглаж буй хувиргасан амьд организм, түүнээс гарган авсан бүтээгдэхүүндээ гарал үүслийн тодорхойлолт, гарал үүслийг тодорхойлсон шошго тэмдэг бүхий тусгай сав, баглаа, боодол хэрэглэнэ.

13.4. Ашиглаж байгаа болон шинээр гарган авсан хувиргасан амьд организмаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн тус бүрт ашиглах, харьцах заавар заавал дагалдаж байна.

14 дүгээр зүйл. Биоаюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

14.1. Биоаюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлнэ:

14.1.1. хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй хувиргасан амьд организмыг өөрийн үзэмжээр сонгож хэрэглэх;

⁴ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль – Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1998 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Төрийн нууцын тухай хууль – Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.



14.1.2 хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй хувиргасан амьд организмыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр улсын хилээр нэвтрүүлэх, гарган авах;

14.1.3 биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулж авах;

14.1.4 биоаюулгүй байдлыг хангах талаар Үндэсний хороонд санал, хүсэлт гаргах;

14.1.5 хувиргасан амьд организмыг гарган авах, ашиглах, улсын хилээр нэвтрүүлэх асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах.

14.2. Биоаюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

14.2.1 биоаюулгүй байдлыг хангах талаархи хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;

14.2.2 хувиргасан амьд организмд итгэмжлэгдсэн эрдэм шинжилгээний байгууллагаар эрсдлийн үнэлгээ хийлгэх;

14.2.3 энэ хуулийн 7 дугаар зүйл болон хувиргасан амьд организмыг гарган авах, ашиглах болон түүнээс үүдэлтэй хор уршгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгахтай холбогдсон заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

14.2.4 хувиргасан амьд организмыг гарган авах, ашиглах явцдаа бусдад хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлөх.

15 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас үүдэлтэй хор уршгаас урьдчилан сэргийлэх, арилгах талаархи иргэн, төрийн бус байгууллагын оролцоо

15.1. Иргэн, төрийн бус байгууллага хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, зөрчил гаргасан бол эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлж болно.

15.2. Иргэн, төрийн бус байгууллага хувиргасан амьд организмаас үүдэлтэй хор уршгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах талаар төрийн болон төрийн бус бусад байгууллагатай хамтран үйл ажиллагаа явуулж болно.

15.3. Энэ хуулийн 15.2-д заасан үйл ажиллагаа явуулахад холбогдох хуулийн дагуу улсын төсвөөс дэмжлэг үзүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

16 дугаар зүйл. Биоаюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны санхүүжилт

16.1. Биоаюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

16.2. Хувиргасан амьд организмаас үүдэлтэй хор уршгийг яаралтай арилгах зайлшгүй нөхцөлд гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

16.3. Хэрэгжүүлэх гэж буй төслийн үр ашиг, ач холбогдлыг харгалзан улсын төсвөөс санхүүжүүлсэн нөхцөлд уг зардлыг тухайн төсөл хэрэгжүүлэгч этгээдээр гэрээний үндсэн дээр нөхөн төлүүлнэ.

17 дугаар зүйл. Хувиргасан амьд организмыг ашиглах, улсын хилээр нэвтрүүлэхэд тавих мэргэжлийн хяналт

17.1. Хувиргасан амьд организмыг ашиглах, улсын хилээр нэвтрүүлэхэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн холбогдох мэргэжлийн хяналтын алба, улсын байцаагч хяналт тавина.

17.2. Мэргэжлийн хяналтын алба, улсын байцаагч нь Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиар¹ тогтоосон эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

18 дугаар зүйл. Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

18.1. Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбогдон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага улсын байцаагчийн хооронд үүссэн маргааныг улсын мэргэжлийн хяналтын байгууллага хянан шийдвэрлэх бөгөөд тухайн шийдвэрийг эс зөвшөөрвөл иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шүүхэд гомдол гаргаж болно.

19 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмын бүртгэл

19.1. Хувиргасан амьд организм гарган авах туршилт явуулах, үйлдвэрлэх эрхтэй байгууллага нь улсын бүртгэлд хамрагдаж, гарган авсан, ашиглаж буй хувиргасан амьд организмыг бүртгүүлж байна.

¹ Төрийн хяналт, шалгалтын тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

19.2. Энэ хуулийн 19.1-т заасан бүртгэлийг Үндэсний хорооны ажлын алба эрхлэн хөтлөнө.

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

20.1. Хувиргасан амьд организмаас үүдэнтэй хор уршгийг арилгах зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

20.2. Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэх үед гарсан зөрчилд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан захиргааны шийтгэл ногдуулна.

20.3. Хувиргасан амьд организмын тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч болон эрх бүхий улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулна:

20.3.1. зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан иргэнийг 25000-50000, албан тушаалтныг 25000-100000 төгрөгөөр торгох;

20.3.2. аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгож, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг илэрсэн зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн, тухайн хувиргасан амьд организмыг устгах.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5 дахь заалтын "...экологийн аюулгүй байдлыг хангах асуудал" гэсний дараа "...биоаюулгүй байдлын бодлого" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувиргасан амьд организмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 2.3-ын "Ашигт малтмалын тухай" гэсний дараа "...Хувиргасан амьд организмын тухай" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувиргасан амьд организмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 4.1.7-гийн "бичил биетний өсгөвөр" гэсний дараа "...биотехнологийн аргаар гарган авсан хувиргасан амьд организм" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувиргасан амьд организмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 07 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 8.6-гийн "шийдвэрлэнэ." гэснийг "уг этгээдийг хэлмэгдсэнд тооцох, эсхүл эдгээр

баримт тогтоогдоогүй бол хэргийг хэрэгсэхгүй болгоно." гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн жагсаалтыг 1 дүгээр, Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Агаарын бохирдлыг бууруулах талаар дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай:

2.1 Дараахь асуудлыг боловсруулж дор дурдсан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх:

а/тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2007 оны намрын чуулганд;

б/Улаанбаатар хотын дэд бүтцийн хангамж, хамрах хүрээг өргөжүүлж, орон сууцаар хангах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, гэр хорооллыг барилгажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон түр суух 1000 айлын орон сууц барих, 2007 онд багтаан гэр хорооллын дахин төлөвлөлт хийж, эхний ээлжинд 10 байрлалд орон сууц барих, гэр хорооллыг барилгажуулахад зарцуулах хөрөнгийн асуудлыг Улсын Их Хуралд яаралтай;

в/Улаанбаатар хотод түлшний зориулалттай түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх, дэд бүтэц, үйлдвэрлэлийн техник, технологийн чадавхи, ажиллах хүчний нөөц боломжид түшиглэн хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй, чанар, стандартын шаардлага хангасан, дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал болон хийн

түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлж, хэрэглэгчдийг хангах төсөл, арга хэмжээний саналыг 2007 оны 10 дугаар сарын 1-ний дотор;

г/дулаан, цахилгааны шинэ эх үүсвэрийг барих техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан байршлыг нь оновчтой тогтоож, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг 2007 онд багтаан.

2.2 дулааны цахилгаан станцуудыг дотоод хяналт-шинжилгээний хэрэгсэл, утаа болон бохирдуулагч бодис шүүх тоног төхөөрөмжөөр хангах, станцуудаас агаарт гаргах хаягдлын зөвшөөрөгдөх хэмжээний стандартыг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3 төсвийн байгууллагын халаалтын нам даралтын зууханд улсын төсвийн хөрөнгөөр, хувийн эзэмшлийнхэд урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр тус тус технологийн шинэчлэл хийх, тэдгээрийн хэрэглэгчдийг төвийн эрчим хүчний системд холбох, сэргээгдэх эрчим хүч, хийн түлшинд шилжүүлэх замаар түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлаж, түүхий нүүрсээр ажилладаг халаалтын нам даралтын зуухнуудын үйл ажиллагааг 2008 оноос эхлэн зогсоох;

2.4 авто тээврийн хэрэгслээс ялгарах утааны бохирдлыг бууруулах талаар үе шаттай арга хэмжээ авах, эхний ээлжинд нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд шилжүүлэх, шатахуун бага зарцуулдаг болон эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй түлш хэрэглэдэг автомашины хэрэглээг дэмжих, стандартын шаардлага хангаагүй автомашин эзэмшигчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, шатахууны чанарыг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох, автомашины ашиглагдсан хуучин дугуйг импортлоор оруулахыг хориглох, хотын төв болон гэр хорооллыг холбосон замыг хатуу хучилттай болгох арга хэмжээ авах;

2.5.дулааны зориулалтаар шөнийн цагаар хямд үнэтэй цахилгаанаар гэр хорооллыг хангах, гэр сууцны дулаан хадгалах чадварыг нэмэгдүүлэхэд нийцүүлэн гэрийн бүтэц, хийцийг оновчтой болгон өөрчлөх арга хэмжээг шинжлэх ухааны байгууллага, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх;

2.6.агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын санал санаачлага, дэвшилтэт технологи боловсруулах, үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагаанд татварын болон санхүүгийн бодитой дэмжлэг үзүүлэх, хотын ногоон байгууламжийг өргөтгөж, хог хаягдлын менежментийг сайжруулах;

2.7.агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны чадавхийг бэхжүүлэх, хяналт-шинжилгээ, судалгааны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх болон лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;

2.8.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийслэлийн болон Засгийн газрын бонд гаргах асуудлыг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

2.9.Улаанбаатар хотын агаарын бохирдол ихтэй тодорхой хэсэгт эрсдлийн үнэлгээ хийсний үндсэн дээр нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах талаар холбогдох арга хэмжээ авах;

2.10.агаарын бохирдлыг бууруулах төсөл, хөтөлбөрт бүх аймгийн төвийг хамруулах;

2.11.агаарын бохирдлыг бууруулах стратегийн зорилтын хүрээнд бүс, аймгийн

төвүүдэд шинээр ажлын байр бий болгох, хөдөө орон нутгийн зах зээлийн орчин нөхцөлийг сайжруулах талаар төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сваруулах зорилгоор дагуул хотуудыг бий болгож хөгжүүлэх, тэдгээрийг холбосон хурдны зам, метро байгуулах үрчдчилсэн тооцоо судалгаа хийх, аймгийн зэрэглэлтэй хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгох эрх зүйн орчин бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу чөлөөт бүс болгох, дэд бүтцийг нь хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх;

2.12.агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, иргэдийн санал, мэдээллийг хүлээн авах, бохирдлын хор уршиг, сөрөг үр дагаврыг арилгах, шинэ дэвшилтэт технологийн ач холбогдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр сурталчлах, энэ чиглэлээр явуулах сургалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх.

3.Гэр хорооллын дэд бүтцийг бий болгох, орон сууцжуулах болон бүсэд үйл ажиллагаанд шаардагдах улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг 2007-2010 онуудад жилд 50.0 тэрбум төгрөгөөс багагүй байхаар тогтоож, жил бүрийн улсын төсөвт тусгахын зэрэгцээ хандивлагч орнууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламж, хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх арга хэмжээ авсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг Байнгын хорооны хуралдаанаар хагас жил тутам хэлэлцэж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Я.Санжмятав/, Төсвийн байнгын хороо /Ч.Улаан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 46
дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР ШИНЭЭР
БОЛОВСРУУЛАХ, ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ**

1. "Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль"-ийн төсөл шинээр батлах;
2. "Агаарын тухай хууль"-ийг шинэчлэн найруулах;
3. "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
4. "Ариун цэврийн тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
5. "Онцгой албан татварын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
6. "Захиргааны хариуцлагын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
7. "Автотээврийн тухай хууль"-д нэмэлт,

- өөрчлөлт оруулах;
8. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
9. "Автотээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татварын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
10. "Татварын ерөнхий хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
11. "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах;
12. "Шингэрүүлсэн шатдаг хий" хөтөлбөрт "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль"-д нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах.

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 46
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР**

1	Улсын төсвоос:
	1.1. Гэр хорооллыг барилгажуулах хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийг бий болгох;
	1.2. Дулааны цахилгаан станц-2 төрийн өмчит хувьцаат компанийг түшиглэн "Дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлш болон хийгээр эрчим хүч үйлдвэрлэх цогцолбор" байгуулах;
	1.3. Дулаан, цахилгааны шинэ эх үүсвэртэй холбогдох дэд бүтцийг барих;
	1.4. "Умард", "Дорнод" дэд станцын хүчин чадлыг өргөтгөх;
	1.5. Агаарын чанарын хяналт-шинжилгээ, судалгааны сүлжээг өргөжүүлэх, мэргэжлийн албыг бэхжүүлэх;
2	Хөнгөлөлттэй зээлээр:
	2.1. Гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцжуулах;
	2.2. "Багануур" хувьцаат компанийн "Экологийн цэвэр түлш, эрчим хүчний цогцолбор байгуулах" төслийг хэрэгжүүлэх;
	2.3. Нүүрсний хийн болон станцартын шаардлага хангасан дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлшний үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих;
	2.4. Шингэрүүлсэн шатдаг хийг нийтийн тээврийн хэрэгсэлд нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх, хий хүлээж авах, түгээх байгууламж барих, хийгээр автомашин цэнэглэх станцын тоог нэмэгдүүлэх;
3	Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар:
	3.1. Дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал түлшний үйлдвэр байгуулах;
	3.2. Дулааны аргаар боловсруулсан утаагүй шахмал болон хийн түлшний зуухны үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
	3.3. Ахуйн хэрэглээний хийн халаалтын систем бий болгох;
	3.4. Хайлааст, Чингэлтэйн чиглэлээр цахилгааны шинэ дэд станц барьж, ашиглалтад оруулах;
	3.5. Гэр, амины орон сууцны дулаалгыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;
	3.6. Агаарын чанарын хяналт-шинжилгээ, судалгааны сүлжээг өргөжүүлэх, мэргэжлийн албыг бэхжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

**Монгол Улсын 2006 оны төсвийн
гүйцэтгэлийг батлах тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2006 оны төсвийн гүйцэтгэлийн орлогыг 1,269,432,732.8 мянган төгрөгөөр, зарлагыг 1,176,658,906.0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монгол Улсын 2006 оны төсвийн жилийн зарлагаас авсан орлого буюу улсын төсвийн ашиг 122,773,826.8 мянган төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх санд төвлөрүүлэн баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

007 оны 07 дугаар
арын 26-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын даргын алба
хашиж байсан Ц.Нямдоржийн хамгаалалт,
хангамжийн тухай**

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг ндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:
1. Монгол Улсын Их Хурлын даргын алба ашиж байсан Цэндийн Нямдоржийг Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрхийн хугацаанд хамгаалах жлыг Төрийн тусгай хамгаалалтын газарт ариуцуулсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд Ц.Нямдоржид Засгийн газраас тогтоосон журмын дагуу суудлын автомашин болон холбоогоор үйлчлэхийг Засгийн газар /М.Энхболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

007 оны 07 дугаар
арын 06-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар
хот

**Ринченгийн Нямаад Монгол Улсын
ардын эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэнд, боловсролын салбарт он удаан ил үр бүтээлтэй ажиллаж, эмч, оюутнуудад эриулсан ном, сурах бичиг, гарын авлага бичиж ийтлүүлэн нүдний эмчилгээнд мэс заслын шинэ аргуудыг нэвтрүүлж, нүдний нарийн мэргэжлийн пон зуун эмч нарыг сургаж бэлтгэх, Монгол Улсад үд судлалын салбарыг үүсгэн хөгжүүлэхэд

оруулсан хувь нэмрийг нь үнэлж Улсын клиникийн төв эмнэлгийн нүдний тасгийн зөвлөх эмч, доктор, профессор Ринченгийн Нямаад Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

007 оны 07 дугаар
арын 06-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар
хот

**Чоймболын Долгорт Монгол Улсын
ардын эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэнд, боловсролын салбарт он удаан ил үр бүтээлтэй ажиллан сургалт, шинжилгээ /далгааны олон бүтээл, ном, сурах бичиг бичиж, энэлгийн нарийн мэргэжлийн эмч, эрдэмтдийг элтгэх, давтан сургах, нийгмийн халдварт өвчнийг үшлон эмчлэх албыг үүсгэн бэхжүүлэх, хүн амын үүүл мэндийг хамгаалахад оруулсан үнэтэй хувь

нэмрийг нь үнэлж Арьсны өвчин судлалын төвийн зөвлөх эмч, доктор, профессор Чоймболын Долгорт Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

007 оны 07 дугаар
арын 06-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар
хот

**Дангаасүрэнгийн Салданд Монгол Улсын
гавьяат эдийн засагч цол хүртээх тухай**

Гадаад харилцаа, худалдаа, үйлдвэр-нийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр /гээлтэй ажиллаж, гадаад орнуудын зээл /сламжийг нэмэгдүүлэн оновчтой ашиглах, /мтарсан үйлдвэр байгуулах зэрэг олон чухал /нал санаачилга гарган хэрэгжүүлж, гадаад /рилцааны олон талт хамтын ажиллагааг өргөтгөх, /э ашгийг дээшлүүлэх, тус салбарын үйл

ажиллагаа, эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Монгол-Сингапурын хамтарсан "Лотс-Инвест" ХХК-ийн дэд захирал Дангаасүрэнгийн Салданд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Цэрэндоржийн Дашдоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан сургалт, эрдэм шинжилгээний олон арван бүтээл туурвиж, Монгол Улсад математикийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, математикийн олимпиадыг үүсгэн хөгжүүлж, сурталчлах, олон улсын олимпиадад багш, сурагчдыг бэлтгэн амжилттай оролцуулахад

оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Монгол Улсын их сургуулийн Алгебрийн тэнхмийн эрхлэгч, профессор Цэрэндоржийн Дашдоржид Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Дансранжавын Лхагвад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Техник мэргэжлийн боловсролын байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн боловсрол, сургалтын менежмент, агуулга, арга зүйг шинэчлэх, сургалтыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах бодлогыг үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж, техник мэргэжлийн сургалтын тогтолцоог бэхжүүлэн

хөгжүүлэх, үндэсний мэргэжилтэй ажилчин бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол-Солонгосын техникийн коллежийн захирал Дансранжавын Лхагвад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Жигжидийн Болдбаатарт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухаан, хууль тогтоох байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж монголын улс төрийн болон төр, эрх зүйн түүх, намтар судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны томоохон бүтээлүүд туурвиж, түүхийн салбарын сургалт, судалгааны ажилд онол-арга зүйн шинэлэг хандлагуудыг нэвтрүүлэн, түүхийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн түүхийн тэнхмийн эрхлэгч, Түүхийн судалгааны хүрээлэнгийн захирал, академич Жигжидийн Болдбаатарт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Цэндсүрэнгийн Баярбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрчим хүчний салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, цахилгаан станцыг шинэчлэн, тоноглох ажлыг оновчтой, зөв зохион байгуулж, шугам сүлжээний тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг дээшлүүлэн, улс орныг цахилгаан, дулааны эрчим хүчээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

"ДЦС-4" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Цэндсүрэнгийн Баярбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Лүүрэвийн Лхагвасүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

